

Б.Эрболд миний бие Орхон аймгийн ИТХ-н сонгуульд бие даан нэрээ дэвшүүлэх хүсэлтээ илэрхийлж, холбогдох хууль, дүрэм, журманд заасны дагуу 3 уриа, бодлогын шинэчлэлтийн хүрээнд 4 үндсэн чиглэлээр өөрийн мөрийн хөтөлбөрөө боловсруулсан. Мөрийн хөтөлбөрийг боловсруулахдаа Монгол улсын үндсэн хууль, Монгол улсын их хурлын сонгуулийн тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын хууль, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 зэрэг хууль тогтоомж, баримт бичгийг удирдлага болгон боловсрууллаа.

Уриа:

1. НЭГДҮЕ!

Нам, эвсэл, нутаг ус, шашин шүтлэг хамаарахгүй Эрдэнэт хотынхоо хөгжлийн төлөө гэсэн нэгдмэл үзэл баримтлалыг бий болгоё.

2. ОРОЛЦОЁ!

Бидний оролцоогүй ӨНӨӨДӨР, бидний хүсээгүй МАРГААШИЙГ бүтээж байна.

3. ӨӨРЧИЛЬЕ!

Эсвэл энэ хэвээрээ үлдье.

Тууштай баримтлах бодлого:

1. Хүртээмжтэй,
2. Оролцоотой,
3. Тогтвортой өсөлтийг хангах.



Иргэдийн оролцоотой хот:

1. Аюулгүй орчинтой, унаган төрхтэй байгалийг хойч үедээ хэвээр өвлүүлэх бодлогыг хэрэгжүүлэх
2. Эрүүл иргэн, амьдралын зөв дадлыг дэмжсэн орчин, нөхцлийг бүрдүүлэх
3. Сайн дурын сонирхлын клубуудын үйл ажиллагааг дэмжих замаар хувь хүний хөгжлийг дэмжих, орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулах боломжийг бүрдүүлэх
4. Хот төлөвлөлт, хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалт болон олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа бүрт төлөвлөлтөөс нь эхлээд үр дүн гарах хүртлэх үйл явцад иргэдийн оролцоог хангах
5. Салбар хоорондын тэнцэл дээр тулгуурлан орон нутгийн төсвийн зарцуулалт, төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, хийгдэж буй ажил үйлчилгээнд хяналт, үнэлгээ хийхэд олон нийтийн болон ТББ-уудын ОРОЛЦООГ хангаж, сайжруулах механизмыг нэвтрүүлэх
6. Хог дахин боловрсуулах, оршуулгын газрын үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн менежментээр цоо шинээр зохион байгуулах

Бизнест таатай хот:

1. Бизнесийн шударга өрсөлдөөн, тэгш боломжтой байдлыг хангах замаар хамгийн таатай орчныг бүрдүүлэх
2. Төсвийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээг худалдан авах тухай хуулийг орон нутгийн хөгжил, орон нутгийн ААН-үүдэд илүү үр өгөөжтэй болгох
3. НҮСЭР төрөөс ТӨСӨР төр байх, төрийн бүх үйлчилгээг цахимжуулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчим дээр тулгуурлан хэрэгжүүлэх
4. Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын албан тушаалын томилгоог улс төрөөс хэт хараат байдлыг хязгаарлах замаар мерит тогтолцоог хэрэгжүүлэх
5. Бизнес эрхлэгчдийг шалгадаг, торгодог зарчим халах, хүнд суртлыг арилгах
6. Өөрөө өөртөө ажлын байр бий болгох санаачлагыг дэмжих, дундаж давхаргыг тэгш боломж олгох нөхцлийг бүрдүүлэх
7. Аймгийн хэмжээнд батлагдсан болон хэрэгжиж буй бодлогыг үргэлжлүүлэн үр дүнг гаргах

Оюунлаг залуусын хот:

1. Бүтээлч аж үйлдвэрлэлийн салбар болон мэдээлэл технологийн гарааны бизнесийн эко системийг бүрдүүлэх
2. Мэргэжлийн боловсролын тогтолцоог аж үйлдвэрлэлийн 4 хувьсгалтай уялдуулан шинэчлэх
3. "Англи хэлтэй хот" хөтөлбөрийг аймгийн ЗДТГ, Боловсрол соёлын газар болон бусад сургалтын байгууллагуудтай хамтран зохион байгуулах
4. Эрдэнэт хотоос гадаадад амжилттай ажиллаж суралцаж байгаа залуучуудын нөөцийг хотын хөгжилд ашиглах платформыг зохион байгуулах

Эрдэнэт 20/30/40:

1. Сайн засаглал, ил тод, улс төрөөс ангид, хариуцлагатай уул уурхайн зарчмыг бүрэн нутагшуулах
2. Хангайн бүсийн төвийн хувьд бүсийн давуу тал, нөөцөд тулгуурлсан боловсруулах үйлдвэрлэлийн кластерийг хөгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх
3. **Тусгай хөтөлбөрүүд:** Аймгийн ЗДТГ болон холбогдох бусад байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх. Үүнд:
 - Залуу хот
 - Бүтээлч хот
 - Аюулгүй хот

